**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН**
**2022 ОНЫ 8 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

**2022.08.26** **Дархан-Уул аймаг**

## 1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛ

**Геодези, зураг зүйн, кадастрын хүрээнд:**

- Хаягийн зургийн дагуу 5 иргэн, 1 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.
- Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж/ хэмжилт хийлгэсэн 10 иргэн, 2 аж ахйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан.
- 3 Сумын Засаг дарга, Газрын даамал руу албан бичиг төлөвлөж явуулсан.
- Шинэчилсэн бүртгэлд хамрагдах шаардлагатай 76 иргэний мэдээллийг нөхөн бүрдүүлж мэдээллийн санд оруулсан.
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дэргэдэх Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх хуралд : Хамтран өмчлөгч хасуулах 26 иргэн, Талбай хэмжээ өөрчлөх 8 иргэний материалыг материалыг бэлтгэв.
- Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлсэн 40 иргэний материалыг хянаж өмчлөх эрхийг шилжүүлсэн.
- Зөвшөөрөлгүй хашаагаа сунгасан 6-р баг ханжаргалан 1-2а, 7-р баг майхант 8-110, 7-р баг майхант 8-111, 3-р баг хараа 3-59, 15-р баг мангирт 10-р хэсэг 5-47, 8-р баг манхантолгой 3-7 тоот айлуудад мэдэгдэх хуудас хүргэсэн.






`

## 2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛ

**Инженер, дэд бүтцийн хүрээнд:**

- ✓ **Засгийн газрын 213-р тогтоолын дагуу барилга ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2 барилгад олгосон. Үүнд:**
  - Цахир түмэн алтай ХХК-ний Шарын гол сумын дулааны шугамын өргөтгөлийн ажил
  - Өгөөмөр баян булаг ХХК-ний цэвэр усны шинэчлэлтийн ажил
  - ДСЦТС ХК жимс дэд станцын шинэчлэлтийн ажил.
- ✓ **Хүргүүлсэн албан тоот**
  - Мөнх болор эрдэнэ ХХК архитектор төлөвлөлтийн даалгавар хүсэх тухай албан тоотод хариу хүргүүлсэн.
  - Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХХК 2022.08.18 өдрийн №196 тоот албан тоотын хариуг хүргүүлсэн.
  - Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК ирүүлсэн албан тоотын хариуг хүргүүлсэн.
  - Дархан суманд 2023 онд хийгдэх Хөгжлийн хөтөч гүйцэтгэж буй авто замын зураг төсөлд шаардлагатай газар олголтын захирамжийн төслийг боловсруулж ХБТХОХ-т хүргүүлсэн.
- ✓ **Оролцсон хурал**
  - Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын хуралд 7 хоног бүрийн 2 дах өдөр оролцсон.
  - Дархан сумын 6,7-р баг 1-р сургуулийн урд талын авто зам хийгдэхтэй холбоотой газар чөлөөлөлтийн хуралд оролцож чөлөөлөх айл өрхүүдтэй уулзалт хийсэн.
- ✓ **Барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулсан талаар:**

- Засгийн газрын 2011 оны 212-р тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм, Дархан-Уул аймгийн засаг даргын 2021 оны 01-А/313 тоот томилогдсон захирамжийн дагуу барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэн 4 барилгад ашиглалтад оруулах үйл ажиллагаанд гишүүнээр оролцож ажилласан. Үүнд:
- Дархан сум, 3-р баг, “Херо хүдэр” ХХК-ний төмрийн хүдэр нойтон баяжуулах үйлдвэр
- Дархан сумын 1,4,7,12,16-р багуудад Япон улсын буцалтгүй тусламжаар хийгдсэн 9206-МОН төслийн 5 ширхэг контейнер тохижуулж суурилуулалтын ажил
- Дархан сум, 31-р хорооллын гадна цэвэр ус, бохир, цахилгаан хашаажуулалтыг ажил

**Барилгын материалын чиглэлийн хүрээнд:**

Барилгын хөгжлийн төвийн дэргэд дэх Барилгын материалын сорил шинжилгээний төв лабораторит 5 хоног тоног төхөөрөмж дээр дадлага хийсэн.

Жил бүрийн Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан үр дүнгийн гэрээний 3.5.3-д заасан БХТөвийн дэргэдэх Барилгын материалын сорил шинжилгээний төв лабораторид аймгийн БМСШЛабораторийн мэргэжилтэн, лаборантуудыг чадавхжуулах, дадлагажуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол авах тухай тусгагдсан байдаг. Иймд дээрх хугацаанд ажлын 5 хоног дадлага хийж ажиллаа. Дадлагаар тайланг жилд 2 удаа хийж хүргүүлэх тухай, мөн иж бүрэн лабораторийн байх ёстой тоног төхөөрөмжийг хэрхэн ажиллуулах, дээж хэрхэн авах, дээж анх авснаас эхлээд өүртгэлийн дэвтэрт хөтлөлт хийх тухай, код өгөх, тухайн бүтээгдэхүүнд тохирсон стандартыг ашиглах тухай, тооцооллыг бодох аргачлал, дээжээс гарсан шинжилгээний хариуг албан бланк дээр буулгаж хүлээлгэн өгөх бүртгэл хөтлөлт зэргийг суралцсан.







Арматур лаборатори

Хуванцор цонх хаалганы лаборатори

Бетон эдлэлийн лаборатори





Орц найрлага тогтоох












## 3. <u>ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖЛЫН ЧИГЛЭЛ:</u>

**Шүүхийн мэдээлэл:**

- Улаанбаатар менежмент ХХК-ний нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох Захиргааны хэрэгт холбогдуулж газар эзэмших эрхийг шилжүүлэхгүй байгаа нь хууль бус гэсэн нэхэмжлэлийн шаардлагад ГХБХБГ-ы ЗХАХМэргэжилтэн Б.Золбаясах хариу тайлбарыг боловсруулж Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд тайлбарыг хүргүүлсэн. Нэхэмжлэгч талаас компанид хувь оруулсан 2 иргэн нь 3-дагч этгээдээр оролцох хүсэлт гарсаныг шүүгчээр татгалзсан шийдвэр гарсаны дагуу Давах шатны шүүхрүү гомдол гаргасан, одоогоор шүүх хуралдааны тов зарлагдаагүй байна.
- "Алтантүрүү" ХХК-ны нэхэмжлэлтэй иргэний хэргийн шүүх хуралдааныг нэхэмжлэгч талаас хуулийн үйлчилгээ авах шаардлагатай тул 7 хоногоор хойшлуулах, өмгөөлөгч Б.Содболд хэргийн материалтай танилцах, хүсэлт гаргаж дахин хойшлуулж 2022/05/25-нд 09:00 цагт хуралдахаар шийдвэрлэсэн.
-

**Хүний нөөц, дотоод ажлууд:**

- 2022 оны 05-06 сард нийт 13 албан хаагчид батлагдсан хуваарийн дагуу "Газрын мэдээллийн цахим систем"-д иргэд, хуулийн этгээдээс газартай холбоотой өргөдөл, хүсэлт, лавлагаа, мэдээллийг egazar.gov.mn сайтаар илгээж, үйлчилгээг нээлттэй түргэн шуурхай хүргэж ажилласан.

**Хууль, тогтоомж:**

- 8 иргэн, хуулийн этгээдийн Газар эзэмших эрхийг хүчингүй болгуулхаар аймгийн Засаг даргын захирамжийн төслийн боловсруулж, хяналтын хуудсаар тойрох хуудас зуруулж, аймгийн Засаг даргын туслах О.Уянгад файлаар хүргүүлсэн.
- Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх 2022.05.20-ны өдрийн хурлаар 101 иргэн, хуулийн этгээдийн газрын асуудлыг танилцуулж, захирамжийн төсөлд илгээлээ.
- "Байгууллагын ёс зөвлөлийн дүрэм", "Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг боловсруулж газрын тушаалаар 2022/05/23-ны өдрийно А/12 тоотоор батлуулж, нийт албан хаагчдад танилцуулж, байгууллагын сайтад байршууллаа.
- ГЗБГЗЗГ-ын даргын 01 албан даалгаврын хэрэгжилтийг хагас жилийн байдлаар тайланг боловсруулж 2022/05/25-нд хүргүүлсэн.
- ГЗБГЗЗГ-т хагас жилийн байдлаар Хууль тогтоомжын хэрэгжилтийн тайланг боловсруулж, хүргүүлхээр ажиллаж байна.
- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг газрын даргын 2022/05/23-ны өдрийн Б/13 тоот тушаалаар шинэчлэн батлуулсан.
- Сод монгол групп ХХК-ний Дархан захын хажууд байрлах ШТСтанцын үйл ажиллагаа явуулж, Худалдаа үйлчилгээний зориулалтын дагуу явуулахгүй байгааг 2022/04/29-ний өдрийн №246 тоот Мэдэгдэлийг хүргүүллээ.

**ЭБАТ:**

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын эрх зүйн харилцааны хуралдааны 8 дугаар сарын хуваарийн дагуу Ашиг сонирхлыг

зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг 6 албан хаагчаас авч https://meduuleg.iaac.mn/AOS/Login бүртгэлд оруулсан. Газрын эрх зүйн харилцааны хуралдааны хуваарийн дагуу хуралдаж нийт **101** иргэн, хуулийн этгээдиийн газартай холбоотой материалыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

## Мэдээлэл технологийн чиглэлээр:

Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 70376471 нээлттэй утсаар 7, Facebook хуудсанд ирсэн 5 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт, зөвлөгөө өгөв.

2022-08-12-ны өдөр цахим төв дээр жижүүрлэж иргэдэд газрын цахим системд хэрхэн нэвтрэх, хүсэлт илгээх талаар заавар, зөвлөгөө өгч ажиллав.






31-р хороололд газар олгож буй талаарх мэдээлэл бүхий бичлэгүүдийг Фэйсбүүк хуудаснаас олж, татаж авч Амины орон сууц хариуцсан мэргэжилтэнд өгөв.










Байгууллагын цахим хуудасны Мэдээ, мэдээлэл цэсний Газрын харилцаа хэсэгт 1ш /2022 оны бэлчээрийн фотомониторинг хийгдэж буй тухай мэдээ/, барилга хот байгуулалт хэсэгт 1ш /Дархан-Уул аймгийн хэмжээнд баригдаж буй барилгуудын үнэ ханшийн мэдээ/ мэдээлэл оруулав.




Байгууллагын Facebook хуудсанд 2022 оны бэлчээрийн фотомониторинг хийгдэж буй тухай мэдээ, Дархан-Уул аймгийн хэмжээнд баригдаж буй барилгуудын үнэ ханшийн мэдээг оруулав.







Серверийн өрөөний кондишны усыг 2 удаа асгаж цэвэрлэн, серверийн өрөөнд цэвэр агаар оруулж цэвэрлэгээ хийв. Сканерыг 2 мэргэжилтэн дундаа хэрэглэхээр болгож тохиргоог хийв. Sample point, dotnet framework програмыг 1 компьютерт суулгаж өгөв.




Шинээр томилогдсон 1 мэргэжилтнийг Абле системд бүртгэж, нэвтрэх боломжийг олгов. Хонгор суманд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдах болсон тул шаардлагатай брошуруудыг даамалд өгөв.

`




## Нярав:

10 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалж мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 5 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 56 ширхэгийг хүлээж авч бүртгэв.

Шаардах хуудсаар 4 төрлийн 10,5 ширхэг бараа материал олгов. 7-р сарын бараа материал, нэгж талбарын хувийн хэргийн хавтасны зарцуулалтын тайлангийн нэгтгэлийг гаргаж ня-бо-д өгөв.

## Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар:

- ГХБХБГ-т 2022 оны 08 сарын 01-ний өдрөөс 08 сарын 29-ны өдрийн хооронд Абле программд нийт 112 албан бичиг /хариутай 102/, 24 өргөдөл /хариутай 24/ ирсэнээс 44 албан бичиг, 3 өргөдөл шийдвэрлэн, 58 албан бичиг, 21 өргөдөл хяналтанд бүртгэжээ.

*Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:*

**График 1. Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлт, хяналтанд авч судлаж буй талаарх мэдээлэл**







- Мөн Egazar.gov.mn системээр 177 өргөдөл хүсэлт хүлээн авсан бөгөөд тус системийн шийдвэрлэлтийн тайлан гаргадаг цэс нь одоогоор ажиллахгүй байгаа тул шийдвэрлэлтийн дүнг гаргах боломжгүй байна.

`

**БОЛОВСРУУЛСАН:**

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ЗОЛБАЯСАХ

**ХЯНАСАН:**

ГАЗРЫН УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН ДАРГА Г.НЯМДОРЖ